



БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
М.ДАШПУНЦАГ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.07.31 № 224

танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Мөнхийн Дашпунцагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,

0702 00835

УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

М.Дашпунцагийн Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

М.Дашпунцагийн мөрийн хөтөлбөр (.....1..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



ӨГҮНЖИДМАА

**Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны сонгуульд бие даан нэр дэвшигч
М. Дашпунцагийн мөрийн хөтөлбөр**

1. Малын үүлдэр угсааг сайжруулах ажлыг малчидтай хамтран хэрэгжүүлнэ.
2. Малын ногоон тэжээлийг хаваржаа өвөлжөөн дээрээ тариалж сурах туршлагыг малчидтай хамтран хэрэгжүүлнэ.
3. Хуримтлалтай малчин хөтөлбөрийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
4. Худаг ус шинээр гаргах, булаг усны эхнийг хамгаалах ажлуудыг нутгийн иргэд болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
5. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох сайн туршлагуудыг иргэд, олон нийтийн байгууллага, сайн дурынхантай хамтран хэрэгжүүлнэ.
6. Мод тарих иргэдийн санаачилгыг дэмжиж ажиллана.
7. Боловсролын шинэчлэлийн хүрээнд шилдэг багш хөтөлбөрийн сумын иргэд, байгууллагууд, олон нийттэй хамтран хөтөлбөр хэрэгжүүлнэ.
8. Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг иргэд олон нийтийн байгууллагуудтай хамтран боловсруулж, иргэдийн оролцоо дээр тулгуурлан хэрэгжүүлнэ.
9. Орон сууцны хөтөлбөрийг банк санхүүгийн болон барилгын компаниудтай хамтран хэрэгжүүлнэ.
10. Дотоодын аялал жуулчлалыг сумын иргэд аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.